



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

ЗГХА Соёл, урлагийн газрын дарга Н.МӨНХЗУЛ



СОЁЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРАГЛАЛ

СОЁЛЫН ЯАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

ЗАХИРГАА
УДИРДЛАГЫН
НЭГЖ

БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН
НЭГЖ

УРЛАГ, УРАН
БҮТЭЭЛИЙН
БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН
НЭГЖ

СОЁЛЫН ӨВИЙН
БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ,
БҮРТГЭЛИЙН
НЭГЖ

ҮНДЭСНИЙ БОЛОН
ОЛОН УЛСЫН
АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН
НЭГЖ

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ,
ДОТООД АУДИТ,
МОНИТОРИНГИЙН
НЭГЖ

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР /22/

НОМЫН САН-24, ТЕАТР-25, МУЗЕЙ 24, СОЁЛЫН ТӨВ (ОРДОН)-341, НИЙТ 414 БАЙГУУЛЛАГА

Соёлын бодлого,
хууль тогтоомжийг
хэрэгжүүлэх ажлыг
улсын хэмжээнд
зохион байгуулах

Аймаг, нийслэлийн
Соёл, урлагийн
газрыг удирлага,
зохион
байгуулалтаар
хангах

Соёлын салбарт
хэрэгжих төсөл,
хөтөлбөр арга
хэмжээний
хэрэгжилтийг улсын
хэмжээнд зохион
байгуулах

Соёлын үйл
ажиллагаан дахь
болон соёлын өвийн
хяналтыг зохион
байгуулах

Соёлын үнэт зүйл,
статистикийн
бүртгэл
мэдээллийн санг
бүрдүүлэх, эрхлэн
хөтлөх

Бүх нийтийн соёл
гэгээрийн
бодлогын
хэрэгжилтийг
хангах

Түүх, соёлын дурсгалт
зүйлийг хадгалж
хамгаалах бодлого,
хууль тогтоомжийн
хэрэгжилтийг улсын
хэмжээнд зохион
байгуулах

Соёлын өвийг
дэлхийн өвийн
жагсаалтад
бүртгүүлэх ажлыг
зохион байгуулах,
бүртгэгдсэн өвийг
хамгаалах


Соёлын биет бус
өвийг хадгалан
хамгаалах, өвлөн
уламжлуулах

Хүний эрх, Соёлын
эрхийн хамгаалал,
соёлын өвийн гэмт
хэргээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх
чиглэлээр мэргэжлийн
байгууллагатай хамтран
ажиллах



ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу боловсруулан баталж жилийн хугацаанд хэрэгжүүлсэн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг ашиглан гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар 96% буюу “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН” гэж үнэлэгдсэн.





НЭГДСЭН АГУУЛГА, УРИАН ДОР ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



Үндэсний их баяр наадмын соёл урлагийн арга хэмжээ

- 8 арга хэмжээ
- Үзэгчдийн тоо 80.000



“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль

- 7 ай савын хүрээнд 273 тоглолт
- 109 хөтөлбөрт арга хэмжээ
- Үзэгчдийн тоо 24.900



“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээ

- 860 арга хэмжээ
- Үзэгчдийн тоо 258.787



Соёлын бүтээлч сар

- 1892 арга хэмжээ
- Үзэгчдийн тоо 523.074



Соёлын орон зай

- Үзэгчдийн тоо 15.000



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ТОМООХОН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ АНХ УДАА НЭГДСЭН ӨНГӨ, ТӨРХ, НЭГДМЭЛ АГУУЛГАТАЙГААР ЗОХИОН БАЙГУУЛАВ






УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ТОМООХОН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КОНТЕНТ, БҮТЭЭГДЭХҮҮН



24+ Боловсрол олгох агуулга
22+ Аймгуудын нэвтрүүлэг
19+ Өвлөн уламжлагчдын нэвтрүүлэг

4 Баримтат кино нэвтрүүлэг

2 Каталог



Бэлгэдэл амьтдын (маскот дүр) анимэйшн -17

Бөхийн тайлбар - 3

Сур харваа - 3

Хурдан морь - 3

300 төрлийн постер, Сошиал сурталчилгаа 126 контент



“Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2022” арга хэмжээнд Хүүхдийн номын хүрээ байгуулан хүүхэд багачуудад зориулсан Үлгэр ярих цаг, циркийн үзүүлбэр, урлагийн тоглолт зэрэг соёл, урлагийн олон талт ажлуудыг зохион байгуулсан. Хүүхдийн номын хүрээгээр 200 гаран хүүхэд багачуудад үндэсний бичиг соёл, номыг сурталчлах, бүх нийтийн уншлагыг дэмжих соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулсан



“Соёлын орчин, орон зайг бүрдүүлж хөгжүүлэх” арга хэмжээний үеэр хүүхэд залуучуудын авъяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг дэмжин Хамтдаа дуулья, Хамтдаа зуръя, Хамтдаа бүжиглэе зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулан 200 гаруй хүүхэд залуусыг хамруулсан.



21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 529,074 иргэд, үүнээс 153,017 хүүхэд, 3,160 тусгай хэрэгцээт иргэд оролцов.



БАЙГАЛЬ БОЛОН ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



“Үзэнгээ суралцъя” өртөөчилсөн аялал зохион байгуулж 10 өртөөгөөр аялуулан үндэсний өв соёл уламжлалаа танилцуулж, үндэсний үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнээр 400 хүүхэд багачуудыг урамшуулав.



3 өдрийн турш нийт 200 гаруй тусгай хэрэгцээт иргэдийг зохион байгуулалттайгаар автобус унаа, хөтөч тайлбарлагч, дохионы хэлмэрчтэйгээр хамрууллаа.

- Байгаль орчинд ээлтэй байдлаар морь, үхэр, сарлаг зэрэг хөсөг тэргийг ашигласан,
- Нүүдэлчдийн байгаль хамгаалах арга ухааныг эрхэмлэн байгаль орчинд ээлтэй, эко орчныг бүрдүүлж тэг хаягдал (zero waste) буюу аливаа бүтээгдэхүүн, нөөцийг боломжит хязгаарт нь хүртэл дахин ашиглаж, хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нүүрс төрөгчийн ялгарлыг (carbon limited) бууруулахын тулд эрчим хүчний хэрэглээг багасгах зэрэг нөлөөллийн ажлуудыг хийсэн.

Жижиг дунд бизнес, хоол үйлдвэрлэгчдийн дэмжлэг:
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн **90** гаруй бизнес эрхлэгч **656,700,000** орчим төгрөгийн эргэлт.

Дотоодын аялал жуулчлалын шууд бус эдийн засгийн өгөөж:
Горхи-тэрэлжийн бүсийн **75** жуулчны баазад **10,198** орчим **хүн/хоногийн** эрэлт үүсгэж **407,920,000** төгрөгийн эргэлт бий болгов.





СОЁЛЫН ӨВИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГООР ӨВИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УЧИРЧ БУЙ ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛЛОО



Монгол үндэсний хоол, идээ ундааны судалгааны ажил:

21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион
байгуулав.



СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгаа:

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд
анхан шатны байдлаар бүртгэгдсэн 21
аймгийн 8142 өвлөн уламжлагч судалгаанд
хамрагдсан



Дурсгалт газар:

9253 дурсгалт газраас
9127 дурсгалт газрыг тооллогод хамруулсан.



САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НЭГДМЭЛ ОЙЛГОЛТОД ТУЛГУУРЛАН СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛЖ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛНЭ



"ГАМШГИЙН ҮЕД СОЁЛЫН ӨВИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ"

Гарын авлага, хэвлэлтийн тоо: 300ш
ЮНЕСКО болон Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сэргээн засварлалтын олон улсын судалгааны төв (ICCROM), Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран бүтээсэн.



Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт 130 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын 1700 дурсгалд эрсдэлийн үнэлгээ хийсэн

Шинээр илрүүлсэн дурсгал:
10 гаруй дурсгалт газрын 250 орчим дурсгалыг шинээр бүртгэв.



АВРАН ХАМГААЛАХ АЖИЛ, СУДАЛГАА Хамтрагч байгууллага:

ШУА-ийн Археологийн хүрээлэн

Авран хамгаалах дурсгал:

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Наран багийн бөөгийн Цагаан, тус сумын Баянбүрд багийн нутаг Ханан, Ховд аймгийн Дуут сумын нутаг Хар бэлчир хэмээх газрын хадны оршуулга

Ач холбогдол:

Дундад эрт үеийн нүүдэлчдийн түүх, соёлыг тодруулах, музейн сан хөмрөг, бүртгэл мэдээллийн санг баяжуулах



САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НЭГДМЭЛ ОЙЛГОЛТОД ТУЛГУУРЛАН СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛЖ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛНЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, холбогдох яам, агентлаг, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага буюу ИНТЕРПОЛ, Итали Улсын Соёлын өвийг хамгаалах цагдаа буюу Карабинери зэрэг 20 гаруй байгууллагын 200 гаруй төлөөлөл танхимаар болон цахимаар оролцож илтгэл хэлэлцүүлэн, зөвлөмж гаргав.



“Музейн аюулгүй байдлыг хангах нь” хэлэлцүүлэг

- Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар Төрийн болон орон нутгийн музей
- Музейн болон гэрээт харуул хамгаалалтын ажилтнууд
- Цагдаагийн байгууллагын албан хаагчид зэрэг нийт 80 гаруй оролцогчид хамрагдав.

“Соёлын өвийн хамгаалал” сургалт, хэлэлцүүлэг

Сургалтад Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 21 аймгийн цагдаагийн албан хаагч, мэргэжлийн хяналтын соёлын хяналтын байцаагч, улс, орон нутгийн музейн сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн санч, дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа зэрэг нийт 140 гаруй оролцогчид хамрагдлаа.



СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛД СОЁЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ



“Гэр бүлийн үнэ цэнэ” өдөрлөгийг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан

Хамтран зохион байгуулагч:
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЗГХА Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар.



“Хүний эрхийн хамгаалал, соёлын гүйцэтгэх үүрэг” хэлэлцүүлэг

Танхим болон цахимаар нийт 238 оролцогчид оролцов.



“Хөшиг нээгдэх бүрт хүргэх нэг үг” уриалгын хүрээнд 270 удаагийн үзвэр үйлчилгээний өмнө хүүхдийн эрх хамгааллыг дэмжсэн агуулга бүхий уриалгыг нийт 31628 орчим хүнд хүргэж, 1800 ширхэг гарын авлага, 600 гаруй мэдээ уриалга үг бүхий зурагт хуудсыг үзэгчдэд хүргэсэн.



Байгалийн түүхийн музей,
Богд хааны ордон музей,
Хархорум музей,
Хэнтий аймгийн музейд
нийт 18 ш үзмэр худалдан авах ажлыг
зохион байгуулав.



Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоол
“Хөгжмийн том хэлбэрийн шилдэг 2022”-д
Х.Алтангэрэлийн “Ганц цагаан шувуу” моно
дуурь, Б.Энхбаяр “Их хааны галын тахилга”
оратория бүтээлүүд шилдэгээр шалгарч
улсын санд худалдан авсан.



Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоол
Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын
санд З.Уянга “Тэнгэрийн хөвгүүд” (2022 он,
88*128, торгон бар),
Д.Гунгаа “Амьдралын хүүрнэл” (2020 он,
70*52/3, цаас, үзэг) нэртэй зураасан зургийн
2 бүтээлийг худалдан авсан.



ӨНӨӨДРИЙГ БАРИМТЖУУЛЖ, ИРЭЭДҮЙН ӨВИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛНА



“100 жил-100 бүтээн байгуулалт” телевизийн цуврал контент бүтээх:
3-5 минутын үргэлжлэх хугацаатай, 5 бүтээн байгуулалт болон үйл явдлыг тусгасан нийт 20 сэдвийн хүрээнд 100 ширхэг контент бүтээгдэж байна.



Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоол Үр дүн: “Түүхийн хүрд баримтат киног Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч байгаа түүхэн тэмдэглэлт үйл явдлыг архивлан хадгалах зорилгоор техникийн болон архивын шаардлагыг бүрэн хангасан 12 бүлэг баримтат киног бүтээж Үндэсний төв архивын газарт хүлээлгэн өгсөн.



“Соёлын баримтат өвийг хадгалж буй байгууллагуудын бүртгэл, мэдээлэл хийх тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр ханган, дадлагажуулах” ажлын хүрээнд тендер зарлаж архивын нягтаршуулсан шүүгээ 16, зөөврийн хард 15, скайнер 5, цаасан баримт ариутгагч 3, баримтын шүүгээ 10 ширхэгийг мэргэжлийн урлагийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.



УРАН БҮТЭЭЛЧ, ИРГЭДИЙН БҮТЭЭН ТУУРВИХ СОНИРХОЛЫГ ДЭМЖИХ ЗАМААР СОЁЛЫН БҮТЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛНЭ




Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, уран бүтээлчдийг дэмжих зорилгоор баримтат киноны уралдааныг зохион байгуулж 13 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Номын сайн нөхөр уралдаан

1. Шилдэг уншигч сурагч (бага анги)
2. Шилдэг уншигч сурагч (Дунд анги)
3. Шилдэг уншигч сурагч (Ахлах анги)
4. Шилдэг уншигч-анги, хамт олон
5. Шилдэг уншигч насанд хүрэгч
6. Шилдэг ном
7. Шилдэг номын сан
8. Шилдэг хэвлэлийн газрыг тус тус шалгаруулав.



Өгүүллэгийн төрөлд 2 орчуулагч
Яруу найргийн төрөлд 1 орчуулагч
тус тус шалгарсан.

“Хандлагаа өөрчилье,
Хамтдаа бүтээцгээе” уриан дор “Соёлын орон зай” бүтээх зураг төслийн уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд уран бүтээлч Д.Ариунболдын “Стрийт арт” цогц бүтээлийн зураг төсөл шалгарсан.





МОНГОЛ УЛСЫГ ОЛОН УЛСАД СУРТАЛЧЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭВ



БНФУ-ын Нант хотын Түүхийн музейд Чингис хаан болон Монголын хаад язгууртны үзэсгэлэнг 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулахаар хамтран ажиллаж байна.



Швейцар улсын Цюрих хот дахь Ритберг музейтэй хамтран 2024-2025 онд “Нүүдэлчдийн хот байгуулалтын уламжлал” үзэсгэлэнг тус музейд зохион байгуулах, улмаар Баруун Европын болон дэлхийн бусад томоохон музейд үргэлжлүүлэн гаргахаар төлөвлөж, “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 06 дугаар сарын 3-ны өдөр байгууллаа.



БНХАУ болон Монгол хоёр улсын ард түмний найрамдал, харилцан ойлголцлыг бэхжүүлэх харилцааг өргөжүүлэх зорилгоор хоёр улсын шилдэг 100 утга зохиолыг орчуулж, хэвлэх тухай санамж бичигт Соёлын сайд гарын үсэг зурж, тус ажлыг зохион байгуулах шинжээчийн хороог байгуулан ажиллаж байна. Тус шинжээчийн хорооны даргаар Соёл, урлагийн газрын дарга томилогдон ажиллаж байгаа бөгөөд шинжээчийн хорооны хурлыг 2 удаа зохион байгуулж хоёр улсын шилдэг 100 бүтээлийг сонгон харилцан санал солилцож, эхний удаад хэвлэн орчуулагдах Монголын 5 бүтээл, Хятадын 10 бүтээлийг тус сонгосон.



ТУВА – УРИАНХАЙ СОЁЛЫН ӨВИЙН ӨДРҮҮД

Урианхай, Тува түмний соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 1000 орчим төлөөлөл болох бий биелээч, туульч, цуурч, аман билэгч, товшуур уртын болон богино дууны өвлөн уламжлагчид хамрагдаж соёлын өвийг олон нийтэд сурталчилсан.



ТӨВ АЗИЙН ТУУЛЬ СИМПОЗИУМ 9 ЖИЛИЙН ДАРАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

- БНХАУ-ын Баруун хойд үндэстний их сургууль
- Өвөр Монголын их сургууль
- Бүгд Найрамдах Халимаг Улсын Олон улсын судалгааны төв
- Халимаг хэл, дорно дахин судлалын хүрээлэн
- Бүгд Найрамдах Киргиз Улсын Олон улсын Манас судлалын академи
- Монгол Улсын холбогдох их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд оролцов.



“ДӨРВӨД, БАЯД БИЙ БИЕЛГЭЭНИЙ ШАВЬ СУРГАЛТ”

Баяд, Дөрвөд угсаатны бий биелгээний үүсэл хөгжил, хөдөлгөөн бүрийн утга тайлал, арга барил, тухайн сурч буй хүний арга барилд тааруулан биед нь зөв шингээх, хүний биеийн таван цул эрхтэн, хавирга, сээр нуруу, хүзүү, гар бугуй бүх үений хэсэг, толгой, нүд, шүд, дотоод сэтгэл, хөлийн суулт зэрэг суурь хөдөлгөөнийг тайлбартайгаар зааж, биелгээний хөдөлгөөн, цацал, мөргөл, ахуйн биелгээ, жороо морь, дөрвөн ойд зэрэг нийт 26 биелгээнүүдийг 50 хүнд язгуур хэв шинжээр нь зааж эзэмшүүлсэн.



САЛБАРЫН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТӨСӨЛД САНАЛ ӨГЛӨӨ.

Хууль болон журмын төсөлд санал боловсруулан холбогдох
байгууллагад хүргүүлсэн.

“Соёл, спорт, олон нийтийн үйл
ажиллагаанд хүүхдийг оролцуулах,
эрхийг хамгаалах” журам

03

“Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг
улсын санд худалдан авах” журам

01

02

“Хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг
улсын санд худалдан авах” журам

04



Үндэсний их баяр наадмын
тухай хуулийн төсөл





Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 40 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт. Соёл, урлагийн газар (ЕС-ын 2022 оны 97 дугаар захирамжаар нэмсэн)

Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2 Соёлын төв өргөө Г корпус 6 давхрын урд хэсгийн 176 м² талбайн өрөө тасалгаанд засвар шинэчлэлийн ажлыг хийж, ажлын байрны тав тух, ажиллах орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллав.





ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

БАЯРЛАЛАА

